

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Бор-Өндөр” УБҮ-ийн усны нөөц, ус ашиглалтын тайлан (усны аудит)

Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/201901195**

1. “Монголросцветмет” ААТҮГ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр” УБҮ-ийн усны нөөц, ус ашиглалтын тайлан (усны аудит) хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Бор-Өндөр” УБҮ-ийн усны алдагдал болон ус хэмнэх нөхцөлийг тогтоож, түүнд шаардагдах хөрөнгийг тооцох, усны хэрэглээнд үнэлгээ өгөн, Монгол Улсын Усны тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн тайлан боловсруулж, Захиалагчтай зөвшилцсөний эцэст эцсийн тайлан батлуулах болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ,
- Шүүхийн тодорхойлолт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт,
- Усны аудит хийх эрх бүхийг батлах тусгай зөвшөөрлийн хуулбар,
- Тендерт оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрийн өргүй байх
- Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар зэрэг болно.

Дээрх баримтууд нь эх хувиараа байх, хэрэв хуулбар хувь бол заавал нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд бүх материалыг pdf файлын хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай харагдахаар цахимаар ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 04 дүгээр сарын 03–ны өдрийн 17⁰⁰ цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 04 дүгээр сарын 09 –ний өдрийн 09⁰⁰ цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ААТҮГ